

СУРГАЛТЫН ТАЙЛАН



“ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН ИЛ ТОД БАЙДАЛ”

Олборлох Үйлдвэрлэлийн Засаглалыг Сайжруулах

Төслийн Ажлын Алба

Эрдэнэс Монгол ХХК

Захиргаа, Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс

2017 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр

СУРГАЛТЫН ЗОРИЛГО:

Монгол Улсын ОУИТБС-ын 2015 онынэгтгэл тайлангаар илэрсэн ТӨК-тай холбоотой нийтлэг алдаа, дутагдлыг танилцуулж, арга зүйн зөвлөгөө өгөх, ОУИТБС-ын стандартаар шаардсан ТӨК-ийн ил тод байдалтай холбоотой мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж чадавхийг бэхжүүлэхэд оршино.

ОРОЛЦОГЧИД:

1. Эрдэнэс Тавантолгой ХК
2. Эрдэнэс Оюутолгой ХХК
3. Шивээ-Овоо ХК
4. Багануур ХК
5. Эрдэнэт Үйлдвэр ХХК
6. Монрос ХХК

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

- Эрдэнэс Монгол ХХК
- Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн ажлын алба

СУРГАЛТЫН АГУУЛГА:

- ОУИТБС-ын тухай ба Монгол улс дахь хэрэгжилт
- ОУИТБС-ын цахим тайлагналын системийн тухай
- Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлангаар илэрсэн голлох асуудлууд
- Олборлох салбар дахь төрийн оролцоо (ОУИТБС-ын стандартын шаардлага 2.66)
- Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлан дахь мэдээлэл, анхаарах асуудлууд
- Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдтэй холбоотой гүйлгээ (ОУИТБС-ын стандартын шаардлага 4.5)
- Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлан дахь мэдээлэл, анхаарах асуудлууд
- ТӨК-ын төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөр (ОУИТБС-ын стандартын шаардлага 6.2)
- Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлан дахь мэдээлэл, анхаарах асуудлууд -
- ТӨК-иудын байгаль орчны нөхөн сэргээлтийн байдал

СУРГАЛТЫН ҮР ДҮН:

1. Сургалтад оролцогч компаниудын санхүүгийн бүртгэл, тайлагнал хариуцсан нэгжийн удирдлагууд, тайлангийн нягтлан бодогчид оролцсоноор ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлагналтай холбоотой илэрсэн алдаа, дутагдлын талаар ярилцаж нэгдсэн ойлголттой болсон.
2. Сургалтад оролцогч компаниудын захиргаа, хуулийн хэлтсийн мэргэжилтнүүд бүгд оролцсон тул компанийн засаглалын тулгуур ойлголт болох ил тод байх зарчмыг хэрэгжүүлэхэд ОУИТБС-ын стандартын ач холбогдлыг ойлгох, энэхүү тайлагналын систем нь дан ганц зөвхөн санхүүгийн нэгжийн тэр дундаа нягтлан бодогчийн хариуцах ажил бус компанийн засаглалтай холбоотой үйл ажиллагаа болох зэрэг мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн.
3. ТӨК-иуд байгаль орчин, орон нутгийн хөгжилд оруулсан хувь нэмрийг тоон болон тоон бус бараа, бүтээгдэхүүнийг ил тод тайлагнах нь эргээд ямар үр дүн, ач холбогдолтой байх боломжтой талаарх мэдээллийг авсанаар санхүүгийн тайланд нийгмийн шинж чанартай төсвийг байгууллагын шинэ жил, ажилчдын урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах зардлыг оруулдаггүй, харин эрүүл мэнд, боловсролын салбарт хөрөнгө оруулж буй бүхий л арга хэмжээг хамруулж авч үзэх шаардлагатай тухай мэдээллийг авсан.
4. Санхүүгийн болон Захиргааны ажилтнууд стандартын дагуу тайлагналыг гүйцэтгэх, байгууллагад ил тод байдлыг хангахад ямар бэрхшээл тулгардаг талаар бүлгийн хэлэлцүүлэг өрнүүлж сорил, бэхшээлүүд, түүнийг хэрхэн даван туулах талаар санал солилцсон.
5. Ижил ажил мэргэжилтэй ажилтнууд хоорондоо танилцаж цаашдын хамтын ажиллагаа улам өргөжүүлэх боломжтой болсон.
6. ОУИТБС-ын тайлан гаргахад ТӨК-дад тулгардаг бэрхшээлийг эхлэлтийн тайлангийн шаардлагад хэрхэн тусгах талаар мэдээллийг аудитын компаниуд авсан. Ингэснээр дараа дараачийн жилийн тайлагнал илүү хүртээмжтэй байх боломжтой.



ХАВРАЛТ:

1. Сургалтын хөтөлбөр
2. Сургалтын PPT материал
3. Оролцогчдын бүртгэл